








Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

“Говь” ХК нь “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниудтай хамтран “Голомт” Банктай байгуулсан зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК, “Таван Богд” ХХК, “Улаанбаатар Гурил” ХХК, “Улаанбаатар Принт” ХХК, “Таван Богд Интернэйшнл” ХХК, “Эйрлинк Монголиа” ХХК, Таван Богд Моторс” ХХК, “Таван Богд Нура” ХХК -уудын хамт Голомт Банктай байгуулсан 2018 оны 03-р сарын 19-ний өдрийн ЗББГС210207652/GNPLT тоот Зээлийн багц бүтээгдэхүүний эрхийн хэмжээг 12,000,000,000 /арван хоёр тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлэн 102,000,000,000 /нэг зуун хоёр тэрбум/ төгрөг хүртэл буюу түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаас хэтрэхгүй байх болгон нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.
3. Дээрх Зээлийн багц бүтээгдэхүүний нэмэлт гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:		Ц.БААТАРСАЙХАН
ТУЗ-ИЙН ГИШҮҮД:		Б.АМАРСАЙХАН
		Д.ГЭРЭЛМАА
		А.ЖАРГАЛМАА
		Н.МӨНХБАТ
		Ц.ОРГИЛБОЛД
		Д.ХУЛАН
		Д.ХҮРЭЛБААТАР
		Б.ЦЭЭНЯМ



20²⁵ он 04 сар 10 өдөр











Дугаар 19

Улаанбаатар хот

**Бизнесийн зээлийн гэрээ байгуулах,
Хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах тухай**

“Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК-ууд нь “Голомт Банк”-тай бизнесийн зээлийн гэрээ байгуулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Таван Богд Холдингс” ХХК, “Говь” ХК-ууд нь дараах нөхцөлийн дагуу “Голомт Банк”-тай “Бизнесийн зээл”-ийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн хэмжээ: 18,000,000,000 /арван найман тэрбум/ төгрөг
 - 1.2. Зээлийн хугацаа: 24 /хорин дөрвөн/ сар
 - 1.3. Төгрөгийн зээлийн хүү жилийн: 16.0 /арван зургаан/ хувь, Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн хувьсах 10.0 /арван/ хувь,
2. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгүүдийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.
3. Дээрх Зээлийн гэрээ, Барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:			Ц.БААТАРСАЙХАН
ТУЗ-ИЙН ГИШҮҮД:			Б.АМАРСАЙХАН
			Д.ГЭРЭЛМАА
			А.ЖАРГАЛМАА
			Н.МӨНХБАТ
			Ц.ОРГИЛБОЛД
			Д.ХУЛАН
			Д.ХҮРЭЛБААТАР
			Б.ЦЭЭНЯМ